



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/414

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Соёлын төвийн засвар (Хутаг-Өндөр сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Хурмастын хүлэг” ХХК-тай 214,550,000 (хоёр зуун арван дөрвөн сая таван зуу тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.“Хурмастын хүлэг” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Хурмастын хүлэг” ХХК-ийн захирал (Г.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010391

Аймгийн Засаг даргын 2023 оны  
15 дугаар сарын 29-ны өдрийн  
А.Н.Н. Дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	3 586 821	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техникийн хяналтын зардал	3 586 821	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1 793 410	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	7 985 000	Ү.Бямбасүрэн
5.	Алданги	Хоногт гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,1 хувь байна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас ихгүй байна.	Д.Батцогт
6.	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн
7.	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.	Д.Батцогт
8.	Орон нутгаас авч ажиллах иргэдийн тоо	15 хүн	Н.Батжаргал
9	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.	Ү.Бямбасүрэн